



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 330

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас олон улсын хөрөнгийн
зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Улсын Их Хурлаас 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай” 52 дугаар тогтоол, Засгийн газраас 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдөр баталсан “Үнэт цаас арилжаалахыг зөвшөөрөх тухай” 112 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Засгийн газрын дунд хугацааны үнэт цаасны хөтөлбөрийн хүрээнд гаргах 1,500,000,000.00 /нэг тэрбум таван зуун сая/ америк долларын үнийн дүн бүхий Засгийн газрын үнэт цаасыг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т үүрэг болгосугай.

2. Засгийн газрын үнэт цаасыг олон улсын хөрөнгийн зах зээлд байршуулсан тухай болон арилжааны явцын талаарх мэдээллийг хагас жил тутамд Хороонд ирүүлж байхыг Эдийн засгийн хөгжлийн яам /Н.Батбаяр/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН